



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хууль

Дагаж мөрдөх огноо:

2022 оны 01 дүгээр сарын 01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Гаалийн ерөнхий газар

Хяналтын нэгдсэн төв

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Хяналтын нэгдсэн төвийн гаалийн улсын байцаагч

Дэс түшмэл ТТ-5

Ажлын цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

14193 Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Их тойруу 81-1

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хүнд

Албан ажлын онцгой нөхцөлд хамаарна

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Гаалийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтод нийцүүлэн гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл явцад гаалийн мэдээллийн автоматжуулсан систем, телехяналтын нэгдсэн системийг хослуулан нэгдсэн хяналтыг хэрэгжүүлж, зөвлөмж илгээх, холбогдох нэгжтэй хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Гаалийн мэдээллийн автоматжуулсан систем, телехяналтын нэгдсэн системийг ашиглан гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж байгаа эсэхэд бүрдүүлэлтийн үе шатанд хяналт тавих, зөвлөмж илгээх, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг гүйцэтгэх, үр дүнд дүн шинжилгээ хийх, тайлагнах;
2. Харьяа гаалийн газар, хороодын телехяналтын дэд системийн хэвийн үйл ажиллагааг хангах, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж судалгаа хийх, боомтын барилга байгууламж, албан хаагчдын аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх;
3. Засгийн газрын гомдол, мэдээлэл хүлээн авах 11-11, Гаалийн лавлах 1800-1281 дугаарын утсаар дамжуулан төрийн хууль хяналтын байгууллага болон аж ахуйн нэгж иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх, ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх;
4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах- Т, Гүйцэтгэх-Г Хянах- Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавих, Хяналтын нэгдсэн төвийн дарга болон ахлах байцаагчийг мэдээ, мэдээллээр хангах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г
	2.Гаалийн мэдээллийн автоматжуулсан систем, телехяналтын нэгдсэн системийг ашиглан зөвлөмж илгээх, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг гүйцэтгэх, үр дүнд дүн шинжилгээ хийх;	Мэдээллээр хангасан тоо, үр дүн	Г
	3.Телехяналтын нэгдсэн систем болон гаалийн мэдээллийн автоматжуулсан системийг ашиглан илрүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг Хяналтын нэгдсэн төвийн ахлах байцаагч болон даргад мэдэгдэх, мэдээ, мэдээллээр хангах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г
	4.Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн чиглэлээр ашиглагдах бүх төрлийн мэдээлэл цуглуулах, хүлээн авах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан үүсгэх, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Телехяналтын нэгдсэн систем болон бусад дагалдах систем, програм хангамж, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж санал боловсруулж	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	



	шийдвэрлүүлэх;		
	2.Харьяа гаалийн газар, хороодын телехяналтын дэд системийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлага хүргүүлэх, тоног төхөөрөмжийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, судалгаа хийж шийдвэрлүүлэх;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Засгийн газрын гомдол, мэдээлэл хүлээн авах 11-11, Гаалийн лавлах 1800-1281 дугаарын утсаар дамжуулан төрийн хууль хяналтын байгууллага болон аж ахуйн нэгж иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г
	2.Засгийн газрын гомдол, мэдээлэл хүлээн авах 11-11, Гаалийн лавлах 1800-1281 дугаарын утсаар ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, шаардлагатай нэгжид шуурхай хуваарилан шийдвэрлүүлэх, тайлагнах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Ажил үүргийн хуваарийн дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахдаа эрсдэл тооцож, үр дүнг тайлагнах;	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн	Г
	2.Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодтой хяналтын системтэй холбогдох асуудлаар хамтран ажиллах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г
	3.Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллах;	Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна	Т, Г
	4.Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцүүлэн баримт бичгийн төсөл боловсруулах;	Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байна	Г
	5.Нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой програм хангамжийг боловсронгуй болгох санал өгөх ажлыг зохион байгуулах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г
	6.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг	Хэрэгжүүлсэн	Г

	хугацаанд нь биелүүлэх, олон нийтийг хамруулсан арга хэмжээ зохион байгуулах, оролцох.	арга хэмжээний тоо, үр дүн	
III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> - мэдээлэл, харилцаа холбооны технологиуд (061201-061204, 0613, 0619); - худалдаа (041601); - эрх зүй (042101, 042103); - менежмент ба удирдахуй /041301-041305/. 		
Мэргэшил			
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; - нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; - байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх, харьцуулсан судалгаа хийх; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах; - мэдээлэлд тулгуурлан хууль тогтоомжийн дагуу тодорхойлсон чиг үүргийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ, хийх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах. 	
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - сэтгэн бодох, анализ хийх, хөрвөх чадвартай байх; - өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудгыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - албан тушаалын чиг үүргийн хүрээнд гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох; - удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах; - өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг. 	
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах; 	
	Бусад	<ul style="list-style-type: none"> - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - гадаад худалдаа, гаалийн хөгжлийн чиг хандлагаас суралцан, өөрийгөө хөгжүүлэх; - төрийн албан хаагчийн болон гаалийн улсын байцаагчийн 	



	<p>ёс зүйн хэм хэмжээ, үйлчилгээний стандарт, сахилгын тусгай дүрмийг чанд сахин ажиллах, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;</p> <ul style="list-style-type: none"> - монгол хэл бичгийн мэдлэгийн төвшин нь албан ажлын шаардлагыг хангасан; - харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглан, гаалийн харилцаанд оролцогчидтой харилцах.
--	--

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Гаалийн ерөнхий газрын дарга, Хяналтын нэгдсэн төвийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

- Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хорооны дарга, орлогч дарга, албаны дарга, салбарын эрхлэгч, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч, бусад ажилтан;
- Төрийн болон турийн бус байгууллагын холбогдох ажилтан;
- Иргэн, хуулийн этгээд.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Албан тушаал:
ХУУЛИЙН ХӨЛТӨЙН ДАРГА
..... Ч. ТАМИРАА
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 23 04 18

2023 оны 01 сарын 20-ны өдөр

Дугаар: 120

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/тэмдэг)

ДАРГА Р.ОТГОНЖАРГАЛ

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2023 оны 04 дугаар сарын 18-ны өдөр

